

ТҮГЭЭМЭЛ АСУУДАГ АСУУЛТУУД

1. Яагаад Хараат бус гомдол шийдвэрлэх механизмыг ашиглах вэ?

ХБГШМ нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, нутгийн хүмүүст цаг алдалгүй, шударга бөгөөд хараат бус байдлаар маргаан шийдвэрлэх эсвэл нийцлийн хяналт шалгалт хийх замаар асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэхээр ажилладаг.

2. Гомдол гаргаснаар төсөл зогсох үү?

Үгүй. ХБГШМ-ийн ажлын үр дүнг харгалзан төслийг зогсоох шийдвэр гаргах эрх мэдэл нь УАНС-гийн нарийн бичгийн даргын газар эсвэл Удирдах зөвлөлд байдаг.

3. Гомдол гаргахтай холбоотой эцсийн хугацаа байдаг үү?

Үгүй. ХБГШМ нь УАНС-гийн аливаа төсөл, хөтөлбөртэй холбоотой гомдлыг хүлээн авах боломжтой.

4. ХБГШМ-д гомдол гаргаснаар ямар үр дүн хүлээх ёстой вэ?

Гомдлын дагуу түргэн шуурхай, хараат бус ажиллагаа ба төсөл, хөтөлбөртэй шууд харьцан асуудлыг шийдвэрлэх эсвэл зөрчлийг залруулах зөвлөмж гаргах хараат бус хяналт шалгалт явуулах шударга процесс. Ямар үр дүн гарах нь гомдолд сөхсөн асуудлаас хамаарна.

5. ХБГШМ нь төслийн түвшин дэхь гомдол шийдвэрлэх механизмаас ямар ялгаатай вэ?

ХБГШМ нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд нэн ялангуяа УАНС-гийн бодлого, процедурыг зөрчсөнтэй холбоотой гомдол гаргах бас нэг шугам юм. ХБГШМ нь зохистой гэж үзвэл орон нутгийн гомдол гаргах механизмыг ашиглахыг зөвлөдөг.

ХАЯГ

ХАРААТ БУС ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

Уур амьсгалын ногоон сан

Green Climate Fund

Songdo Business District

175 Art Center-daero

Yeonsu-gu, Incheon 22004

Republic of Korea

✉ irm@gccfund.org

☎ +82.32.458.6485

🏠 <https://irm.greenclimate.fund/>

🐦 @GCF_IRM



GREEN
CLIMATE
FUND

Independent
Redress
Mechanism

Image credit: Neil Palmer

GCF ХАРААТ БУС ГОМДОЛ ХЯНАХ МЕХАНИЗМ (IRM)

ХАРИУЦЛАГА НЭХЭЖ,
ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ
ҮҮДИЙГ НЭЭХ НЬ

Бидний тухай

Хараат бус гомдол шийдвэрлэх механизм (ХБГШМ/IRM) нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар хөгжиж буй улс орнуудад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг сөрөхөд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Уур Амьсгалын Ногоон сангийн хариуцлага нэхэх, гомдол шийдвэрлэх механизм юм. ХБГШМ нь УАНС-гийн нарийн бичгийн даргын газраас хараат бус ба УАНС-гийн Удирдах зөвлөлд ажлаа шууд тайлагнадаг.

Бидний үүрэг

ХБГШМ-ийн үндсэн зорилго нь УАНС-гийн төсөл эсвэл хөтөлбөрүүдэд сөрөг нөлөөлөлд өртөж буй гэж үзэж буй иргэдээс ирсэн гомдлыг шийдвэрлэх, УАНС-г өөрийн бодлого, процедурт үнэнч, хариуцлагатай байхад дэмжих болно.

ГОМДОЛ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

ХБГШМ нь ямар гомдол хүлээн авах вэ?

УАНС-гийн аливаа төсөл, хөтөлбөрийн сөрөг нөлөөлөлд өртсөн эсвэл өртөх боломжтой гэж үзэж буй аливаа иргэн, бүлэг хүмүүс эсвэл нутгийн хүмүүс нь гомдол гаргаж болно.

Уг гомдол нь УАНС-гаас санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөр эсвэл санхүүжүүлэхээр авч үзэж буй төслүүдтэй холбоотой байх шаардлагатай.

Ямар мэдээлэл хэрэгтэй вэ?

Гомдол гаргахад шаардагдах аливаа тусгай маягт байхгүй. Гэсэн хэдий ч гомдолд дараах мэдээллийг тусгасан байх нь зүйтэй:

- Гомдол гаргасан хүний нэр, холбоо барих нэр, холбоо барих хаяг
- ХБГШМ -ийн санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн товч тодорхойлолт
- Хохирол, нөлөөллийн талаархи тайлбар
- Хэрэв ямар нэг төлөөлөгчөөр дамжуулан гомдол гаргаж буй бол нөлөөлөлд өртсөн иргэн (иргэд)- ээс ХБГШМ-ид гомдол гаргахад төлөөлөх эрхийг олгосон тодорхойлолт

ХБГШМ нь ямар ч хэл дээр гомдол хүлээн авдаг. Гомдлыг шуудан, и-мэйл, факсаар эсвэл энэхүү танилцуулгын ард бичсэн хаягаар биечлэн хүргэж өгч болно. Гомдлыг бичгээр, видео, дуу бичлэг хэлбэрээр гаргаж болно.

ГОМДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭДЭГ ВЭ?

- ХБГШМ нь гомдлын **шаардлага хангаж буй эсэхийг үнэлнэ.**
- Шаардлага ханаж буй тохиолдолд ХБГШМ нь шийдэл олох, тохиролцох үүднээс **сайн дурын шийдэлд хүрэх процесст** дэмжлэг үзүүлнэ.
- Шийдэлд хүрэх боломжгүй эсвэл үр дүнгүй бол ХБГШМ нь **нийцлийн үнэлгээ хийж**, УАНС-гийн бодлого зөрчсөн эсэхийг тодорхойлох **хяналт шалгалт явуулж** болох ба зөрчлийг арилгах зөвлөмж гаргана..
- ХБГШМ нь аливаа шийдэлд хүрэх тохиролцоо болон баталсан зөрчлийг арилгах алхмуудын хэрэгжилтэд **хяналт тавина.**

ХБГШМ нь гомдол гаргасан этгээдүүдийн мэдээллийг нууцлах хүсэлтийг хүндэтгэдэг ба өөр ямар нэг байдлаар тохиролцоогүй тохиолдолд ХБГШМ-аас гадуур бусад этгээдүүдээс мэдээллийг нууцалдаг. ХБГШМ нь өөрийн нэрийг нууцалсан гомдол гаргагчаас гомдол хүлээн авдаггүй болно.